

## ГЕОПОЛИТИКИЙН ОРЧНЫ ӨӨРЧЛӨЛТ БА МОНГОЛ УЛСЫН «ГУРАВДАГЧ ХӨРШ»-ИЙН БОДЛОГЫН ПАРАДИГМ

*Д. Уламбаяр\**

*Abstracts: Mongolia is the only state in the Northeast Asian region, which has established with all states legal basis of strategic and comprehensive partnership, and friendly relationship and cooperation framework in bilateral level. In other words, Mongolia has not serious conflicts with countries of the region, and especially no political controversies which became an important achievement in Mongolia's national security. Mongolia's "third neighbor" diplomacy is, besides of geographical policy and understanding, not only related to certain country, it is more concept of theory of international relations emerged on geographical and space specifics and covering areas of politics, economics, geopolitics and security. Mongolia's "third neighbor" diplomacy is geopolitics originated directly from Mongolia's national interests, connected with geographical specific location and in longterm in order to secure and maintain appropriate balance of power in the middle of policies and measures conducting by two neighbors and to ensure national security comprehensively by political-diplomatic and economic means, and in wider context a definition comprising subjects, such as western and eastern democratic, developed countries and UN, influential to world politics, and unbending supporter of Mongolia's democracy and policy of market economy. Theoretical base of "third neighbor" diplomacy is balance of power or soft balancing and balance of interests. Mongolia has found "third neighbors" in its global geopolitical environment and formed necessary legal framework, etc.,*

*Keywords: Geopolitics, National Security, Power, Syber Space, Digitization, Third Neighbor Diplomacy.*

\* \* \*

Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл бүрдсэн байх гэдэг нь даяаршлын үед харьцангуй ойлголт бөгөөд тэгэх тусмаа дангаараа бүрэн хангах боломжгүй юм. **Үндэсний аюулгүй байдлыг хангах ажиллагаа нь тасралтгүй үргэлжлэх үйл явц бөгөөд үүн лүгээ үндэсний аюулгүй байдлын судалгаа, дүн шинжилгээ ч тасралтгүй хийгдэж байх учиртай ажгуу.** «Гуравдагч хөрш»-ийн бодлого бол Монгол Улсын үндэсний аюулгүй байдлаас шууд үүдэн гарсан бодлого мөн.

Бүс нутгийн болон олон улсын аюулгүй байдлын орчинд гарч глобал өөрчлөлт, дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын үр нөлөө, зах зээлийн конъюнктурын хувьсал, дэлхийн дулаарал, цаг уурын өөрчлөлт, байгалийн гамшиг, шинэ өвчний цар тахал, *hybrid* буюу уламжлалт бус аюул зэрэг геополитикийн гадаад орчин, төсөв, мөнгө, хөрөнгө оруулалтын бодлого, хүний эрхийн баталгаажилт, ардчилал,

---

\* ХУИС-ийн Олон Улсын Харилцаа, Нийгэм Судлалын Сургуулийн Захирал, Профессор

засаглалын чанар зэрэг геополитикийн дотоод орчны мэдэгдэхүйц хувьсал улс орны удирдлагыг богино хугацаанд оновчтой, шинжлэх ухааны үндэслэлтэй зөв шийдвэр гаргах, урьдчилан сэргийлэх (дипломат) ажиллагаа, хямралын менежментийг шуурхай хэрэгжүүлэхийг шаардаж байна. Даяаршлын үйл явц улс орнуудын хөгжил, дэвшлийн өмнө өргөн боломж нээж байгаа нь үнэн боловч, жижиг бага улс орнуудын өмнө мөнхүү томоохон эрсдэлтэй асуудлуудыг дэлгэн тавьж байна.

Монгол Улсын өмнөд хөрш 2016 оны байдлаар 1.3 тэрбум хүн амтай, ДНБ-ий худалдан авах чадавхийн (PPP) үнэлгээгээр 13.3 их наяд ам. долларын үйлдвэрлэл явуулж, үүгээрээ Японы урд нэгэнт гарч, АНУ-ын дараа хоёрт орж, гадаад валютын нөөц нь 3.1 их наяд ам. доллараар хэмжигдэж, дэлхийд хамгийн хурдацтай хөгжиж буй цөмийн зэвсэгтэй их гүрэн бол, харин хойд хөрш 145 сая хүн амтай, ДНБ-ий PPP үнэлгээгээр 2.3 их наяд ам доллар, гадаад валютын нөөцөөр 1.1 тэрбум бүхий Японы дараа 500 тэрбум ам. доллараар гуравдугаарт орж сэргэн мандаж буй цөмийн зэвсэгтэй их гүрэн юм. Хоёр гүрэн НҮБ-ын АЗ-ийн байнгын гишүүн бөгөөд өөр өөрийн гэсэн бие даасан онцлог бодлого, байр суурьтай. Дээрх статистик тоо болон баримт нь Монгол Улсын геополитикийн орон зай, ойрхи ирээдүйн нийгэм-эдийн засгийн хөгжилд ямар шүү нөлөө үзүүлэх чиг хандлагатайг тоймлон харуулж байж болохоор байна.

Даяаршлын үйл явцад улс орны бүх салбар хамрагдаж, харилцан хамаарал үндэсний аюулгүй байдлыг тодорхойлогч нэг томоохон хүчин зүйл болов. Ийм түүхэн үед улс хоорондын харилцаанд эрх тэгш байх, шударга байх, олон хэлбэртэй байх, хамтын хариуцлага хүлээх зэрэг үндсэн зарчмын ач холбогдол өсч байна. Даяаршлын боломж бол хамтран ажиллаж, хамтаар хожих явдал мөн.

Монгол Улсын гадаад, дотоод орчин сүүлийн 20 гаруй жилийн өмнөхөөс үндсээрээ өөрчлөгдсөн нь 1994 онд батлагдсан Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлалыг өнөөгийн нөхцөл байдалд нийцүүлэн шинэчлэх зүй ёсны шаардлагын үндэс болов. Гэхдээ 2010 оны Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд суурь зарчим, бүтэц, бүрэлдэхүүн, зарим шинэ нэр томъёог оруулж өөрчлөн шинэчилсэн ч, эрмэлзэх зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ зэрэг зүйл заалтууд нь зарим талаар Засгийн газрын мөрийн хөтөлбөр, таван жилийн төлөвлөгөөний шинжтэй болсныг тэмдэглэх хэрэгтэй. Үзэл баримтлал буюу концепци гэдэг нь сонгодог утгаараа онол-практикт тулгуурласан гүн гүнзгий задлан шинжилгээ, өөрийн боломжит хүч, нөөцөө бодитой үнэлсэн, урт удаан хугацаанд үйл ажиллагаандаа тогтвортой баримтлах зарчим, хэм хэмжээ, стратеги, тактикийн нийлбэр цогц байх ёстой болов уу. Тухайлбал, Монгол Улс даяаршлын нөхцөлд хэрхэн, яаж дасан зохицож хөгжих, энэ явцад үндэсний аюулгүй байдлаа хэрхэн яаж, ямар арга замаар хангах бодлогоо тодорхойлох учиртай. Даяаршлын цоо шинэ эринд үндэсний аюулгүй байдлын гадаад, дотоод таатай нөхцлийг бүрдүүлнэ гэдэг харьцангуй ойлголт юм. Өөрөөр хэлбэл дэлхийн эдийн засаг даяаршиж, бие биенээсээ улам бүр харилцан

хамааралтай болж, хүчирхэг эдийн засаг, батлан хамгаалах хүч чадавхтай улс гүрэн ч өөрийнхөө хөгжил дэвшил, үндэсний аюулгүй байдлаа дангаараа хангаж, хөтлөн авч явах бололцоогүй болсонд оршино. Нөгөө талд харилцан хамаарал гүнзгийрсэн даяаршсан ертөнцөд улс орнууд хоорондоо эдийн засгийн талаар тэнцвэртэй харьцах гэдэг боломжгүй учраас энэ нь харьцангуй юм.

### **Геополитик ба хүч чадал**

Геополитик бол газарзүй, орон зайн байршил, хүч чадавхид суурилсан улс төрийн бодлого даруй мөн бөгөөд XIX зууны сүүлчээр эх үндэс нь тавигдаж, XX зууны эхээр онолын хувьд цэгцрэн хөгжиж, харин дэлхийн II дайны үед практик үйл ажиллагаанд шилжсэн хэдий ч нацист Германы удирдлага түүнийг *lebensraum* буюу «амьдрах орон зайгаа тэлэх» эрмэлзлээ зөвтгөх түрэмгий бодлогынхоо онолын үндэс болгосон билээ. Дайнаас хойших хугацаанд геополитикийн судалгаа ялангуяа ЗХУ, Дорно Европын орнуудад шүүмжлэлд хурцаар өртөгдөх болсон юм.

Хөгжлийнхөө оргил үед голлох геополитик судлаачид улс гүрэн бол «амьд биет» учраас тэлж өргөжиж байх ёстой, эс тэгвээс нөхөж төлжих, хөгжиж дэвших боломжгүй гэсэн чиг шугамыг барьж байжээ. Далайд ноёрхох, колони эзэмшлийн нутаг дэвсгэртэй болох нь дэлхийд нөлөөгөө тогтоох, хүчээр ноёрхохын үндэс гэсэн Альфред Махэн (Alfred T. Mahan), Европ, Ази, Африк нь «дэлхийн арал» бөгөөд түүний төв болсон Евразийн *heartland* буюу «зүрхэн газар»-т хүч нөлөөгөө тогтоовол дэлхийг захирна гэсэн Х.Макиндер (Halford J. Mackinder), Европ, Ойрхи Дорнод, Африк, Өмнөд Америк, Азийн *rimland* буюу «хүрээ хязгаар» бол АНУ-ын хувьд Евразийн гүрнүүдийг хол байлгах хашлага учраас тус орны үндэсний аюулгүй байдлыг хангах амин судас хэмээх Николас Спайкмэн (Nicholas J. Spykman) нарын үзэл онол Америк, Англи, Германы гадаад бодлогын үндэс болж байв. Дэлхийн II дайны дараа АНУ-ын дипломатч, улс төр судлаач Ж. Кеннан (George F. Kennan) коммунизмын түрэлтийг «тогтоон барих» буюу *containment* стратегийг үндэслэсэн юм. Энэ бодлого хүйтэн дайн дуусах хүртэл Өрнөдийн гадаад бодлогын онол-үзэл баримтлал болж байв. Тогтоон барих бодлогын нэг тал нь Н.Спайкмэны «*rimland*»-ын онолын үндэс болсон *spheres of influence* буюу «нөлөөний хүрээ» тогтооход оршиж байв. Цөмийн зэвсэг бол тогтоон барих бодлогын түлхүүр юм. Нөлөөний хүрээ гэдэг нь нэг их гүрний эрх ашгийн хүрээлэлд оршиж буй газарзүйн бүс нутаг бөгөөд нөгөөтэйгүүр бусад гүрэн хөндлөнгөөс уг бүсэд халдах, орохыг «хориглосон» нууц хэлэцээрийн нэр томъёо ажгуу. С. Хантингтоны (Samuel Huntington) нотолж байсанчлан иргэншил хоорондын ялгаа, үүнээс үндэслэсэн зөрөлдөөн геополитик, үндэсний хийгээд глобал аюулгүй байдалд ч жинтэй сөрөг нөлөө үзүүлэх боллоо.

АНУ-ын глобал дипломат бодлогод эдийн засгийн үүрэг эрс нэмэгдэж байгааг онцолж гадаад бодлогоо тодорхойлохдоо: *economics of power* буюу хүчний эдийн засаг, *power of economics* буюу эдийн засгийн хүч гэсэн 2 зарчмийг баримталж байна. *Хэнд хүч чадал байна тэнд оройлол байдаг ажгуу.* Япон, Франц, Англи, Монгол зэрэг улс бол нэгдмэл нэг үндэстэн улс юм. АНУ, Канад, Австрали зэрэг

улс бол бизнес, байгалийн баялаг дээр суурилж буй болсон гүрнүүд юм. Орос гүрэн бол геополитик дээр суурилж буй болсон гэж үзэж болохоор байдаг. Тиймээс геополитикт суурилсан улс олон үндэстэн нэгдмэл байдалд чухал ач холбогдол өгдөг нь ойлгомжтой.

Хүн төрөлхтөн шинжлэх ухаан-технологийн урьд үзэгдээгүй ахиц, дэвшлийг Шинэ мянганд гаргах материаллаг болон оюун санааны үлэмж чадавхтай юм. Мэдээлэл, харилцаа холбооны технологи, өндөр технологийн суурь бүтэц, дэд байгууламж, нэг хүнд оногдох нийтийг хамарсан өндөр хурдны интернетийн сүлжээ, гол эдийн засгийн бүтцүүдийн хоорондох интеграцлал, инновацичлал улс орны хөгжлийн гол хэмжүүр болов.

XX зууны сүүлчийн улиралд хүн төрөлхтний нэг том нээлт нь амьдрах геополитикийн орон зайгаа цоо шинээр “хязгааргүй тэлсэн” явдал юм. Энэ шинэ орон зайг цахим орон зай буюу *cyber space* гэх бөгөөд хүний оюуны бүтээл болсон энэ орон зай хүн төрөлхтний амьдралд онцгой өөрчлөлт гаргаж, цаашид ч олон өөрчлөлт, шинэ зүйлсийг буй болгох нь тодорхой байна. Хүн төрөлхтөн материаллаг зүйлээс хамаарах нь эрс багасах болов. Бодит биет бүхий ертөнц цахим ертөнцөд биет биш болж байгаа нь түүний хамгийн түгээмэл шинж юм. Үүнийг виртуаль ертөнц хэмээмэй. Нөгөө талаас мэдээлэл нь өөрөө үндэсний нөөц баялаг, улс орны хөгжил дэвшилд нөлөөлөх шийдвэрлэх хүчин зүйл болов. Цахим ертөнц ганцхан мэдээлэл солилцох хэрэгсэл байхаа хэдийнээ больж, хил хязгааргүй эдийн засгийн талбар болсон байна. Өөр өөр соёл иргэншил, эдийн засаг, эрхзүйн тогтолцоотой 190 гаруй улс гүрэн интернетэд холбогдож, цахим сүлжээ нь бизнес, олон улсын худалдаа, хөрөнгө оруулалт, татвар, мэдээлэл, боловсрол, теле холбоо, ажил эрхлэлт, эрүүл мэнд энтертаймент гээд нийгмийн бүхий л харилцааг өөртөө нэгтгэж байна.

Үндэсний эдийн засаг дэлхийн зах зээлийн хуулиар зохицуулагдаж, үндэсний баялаг, түүхий эдийн нөөцөө захиран зарцуулах нь нэг улсын эрх мэдэл, хил хязгаараас шалтгаалахгүй болов. XXI зууны олон улсын харилцааны шинж, төлөв нь асар хурдацтай хувьсал, өөрчлөлт, шинээр шийдвэрлэх дэлхий нийтийн болон үндэсний аюулгүй байдлын олон тулгамдсан асуудал болон мэдээлэл-технологийн үсрэнгүй хөгжилтэй уялдан цоо шинэ орон зай, орчин буй болж, олон улсын харилцаанд оролцогчид нэмэгдэж, улс орны дотоод, гадаад бодлогын зааг ялгаа багасч, дэлхийн эдийн засаг, зах зээлийн нөлөө, харилцан хамаарал ихэсч, улс орнууд урьд өмнө байгаагүйгээр харилцан хамаарал улам бүр гүнзгийрч буй өнөө үед олон улсын харилцааны сонгодог буюу уламжлалт дипломат ажиллагаа дангаар тэдгээр асуудлыг шийдвэрлэх боломжгүй болов. Энэхүү геополитик, гео-эдийн засгийн глобал шинэ орчинд эдийн засгийн дипломат ажиллагааны үүрэг, ач холбогдол хэлбэрэлтгүй өсөн нэмэгдсээр байна.

Мэдлэг нь өнөө үед тоон хэлбэрт шилжсэн ба дижитал инновацлагдсан эдийн засаг гэдэг нь тоон технологит суурилсан программчлагдсан хийгээд цахим үйлдвэрлэл, цахим үйлчилгээ, цахим менежмент, маркетингийн үйл явцад

тулгуурласан эдийн засаг болно. Кибер технологийн хурдацтай хөгжлийн үг дагавараар дэлхий нийтийн аюулгүй байдал улам их эрсдэлтэй болж, санамсаргүй байдлаар өчүүхэн зүйлээс ч асар их хор хөнөөл учирч болзошгүй байдал үүсээд буй.

### **Монголын геополитикийн орчны хувьсал өөрчлөлт**

Монгол нь ХХ зууны эхээр Орос-Хятад, Орос-Япон, Орос-Англи, Орос-Францын нууц хэлэлцээрийн үндсэн объект болж Оросын нөлөөний хүрээнд зохих эвээл хамгаалалтын буюу *protectrate* нутаг дэвсгэр эсвэл автономит муж болж байв. 1911 оны тусгаар тогтнолын сэргэлтийн дараа Монголын улс төрийн удирдагчид хоёр хөршөөс гадна «гуравдагч хөрш» гүрнүүдэд ихээхэн ач холбогдол өгч байсан нь *гадаад улс төр, эдийн засаг, соёлын бодлогын чухал чиг шугам* байжээ. Энэ нь юуны өмнө Өрнө, Дорны гүрнүүдээр тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлэх, улмаар тэдгээр орнуудтай худалдааны өргөн харилцаа холбоо тогтоох, өвөрлөгч нутгийг Халхад нэгтгэх замаар Монгол үндэстний улс төрийн нэгдлийг хангах, түүнийгээ бататгах үндэсний эрх ашиг хийгээд аюулгүй байдалтай ямагт холбогдож байв.

1920-иод оны эхэн үеэс Монголын удирдагчид Хэмжээт цаазат хэлбэрээс капитализмд орж боловсрох, Буриад, Өвөр Монгол, Туваг нэгтгэж Халхаар төвлөрсөн монгол угсаатны *Төв Азийн Федераци байгуулах*, хоёр хөрш болон бусад гүрнээр хүлээн зөвшөөрөгдсөн төвийг сахисан *«Швейцари лугаа»* хөгжих, *«гуравдагч хөрш»*-тэй *ad hoc* харилцаа тогтоох зэрэг янз бүрийн хувилбаруудыг эрэн хайж зохих үр дүнд хүрч байсан юм. Гэвч 1930-аад оны эхнээс Коминтерн, ЗХУ-ын дэлхийн хувьсгалын бодлого, явуулгын дүнд БНМАУ Зөвлөлтийн тойрог замд бүрэн орсноор дагуул улс буюу *satellite state* болов. Гэхдээ олон улсын эрхзүйн статусын хувьд Гадаад Монгол нь 1915 оны гурван улсын Хиагтын гэрээгээр Хятадын Бүгд Найрамдах Улсын *suzerainete* буюу эзэн эрхт автономитоос 1924 оны Зөвлөлт-Хятадын хэлэлцээрээр Хятадын *sovereignty* буюу бүрэн мэдэлд шилжих хүртлээ өөрчлөгдөж байв. Харин Монгол-Зөвлөлтийн 1921 оны нууц хэлэлцээр хүчин төгөлдөр үйлчилж, 1924 онд анхдугаар Үндсэн хуулиа баталж, бүрэн эрхт Бүгд найрамдах засгийг тогтоон явуулсан байна. Тийнхүү Гадаад Монголын статус хоёрдмол утгатай болж, энэхүү ойлгомжгүй *status quo*-г 1945 оны гурван гүрний Ялтын маш нууц хэлэлцээр, Зөвлөлт-Хятадын холбоотны гэрээгээр нэг мөр эцэслэн шийдэж, БНМАУ туурга тусгаар *nation state* болох зам дээр эргэлтгүй гарч ирэв.

Монголын тусгаар тогтнол, аюулгүй байдалд саад болж байсан хүчин зүйлүүдийн гол учир нь Монгол-Оросын харилцаан дахь Хятад, Орос-Хятадын харилцаан дахь Монгол, Монгол-Хятадын харилцаан дахь Орос гэгчлэн харилцан хамааралтай боловч, ялгаатай эрх ашиг, сонирхол хосолсон гурвалжин бий болсон явдал юм. Энэхүү эрх ашиг, сонирхол нь *нэгд*, хэзээ ч Хятадын бүрэлдэхүүн хэсэг байгаагүй туурга тусгаар Монгол Улсын хууль ёсны бүрэн эрхт байр суурь, *хоёрт*, Монголыг халхавч, бамбай байлгах гэсэн Хаант Орос, дараа нь ЗХУ-ын хэдийнээс баримталж ирсэн геополитик, *гуравт*, Монголыг Хятадын салшгүй хэсэг гэж

үзэж байсан Өмнөд хөршийн илэрхий бусармаг явуулга, байр суурь байв. Энэхүү гурвалжинд Японы хүчин зүйл чухал байрыг эзэлж байсан юм. *Эцэст нь*, дурдсан гурвалжинд нөлөө үзүүлж байсан голлох оролцогч нь АНУ байсан гэдгийг онцлон тэмдэглэвэл зохино. Ер нь АНУ Монголын тусгаар тогтнолыг албан ёсоор шууд эсэргүүцэн татгалзсан юм уу, эсхүл энэ асуудлыг огт авч хэлэлцэхээс татгалзаж байгаагүй гэдгийг эх сурвалж нотолдог. Олон улсын харилцаа, дипломатын хэв заншилд тогтсоор ирсэн «дуугүй байх нь эсэргүүцсний шинж биш», харин «чимээгүй байх нь зөвшөөрсний шинж» тэмдэг гэж үздэг ёсон буй.

Цаашилбал гол нь гадаад хүчин зүйлсээс шалтгаалж, Монголчуудын тусгаар тогтнолоо олон улсын хэмжээнд баталгаажуулах хүчин чармайлт ХХ зууны туршид үргэлжилсэн юм.

Олон жилийн хүчин чармайлтын үр дүнд 1961 оны 10 дугаар сард БНМАУ НҮБ-д гишүүнээр элсч, хууль ёсныхоо байр суурийг баттай эзэлж, дэлхийн хамтын нийгэмлэгийн бүрэн эрхт 101 дэх гишүүн болсноор тус улсын тусгаар тогтнол олон этгээдээс баталгаажиж, Монгол Улс тусгаарлагдмал байдлаас гарах, дэлхий дахинаа тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд өөрийн хувь нэмрийг оруулах боломжийг нээв. Гэвч аанай л энэ боломжийг дүүрэн ашиглаагүйгээр зогсохгүй хүйтэн дайны улмаас НҮБ-ын индэр эсрэг тэсрэг хоёр системийн үзэл суртлын тэмцлийн талбар болж Монгол Улс ч түүнд татагдан оржээ.

1960-аад оноос Зөвлөлт-Хятадын харилцааны хүйтрэл Монголын геополитикийн орчныг дахин өөрчлөв. БНМАУ социалист хамтын нөхөрлөлийн «уялдуулан зохицуулсан гадаад бодлого» гэгчийг хөдөлбөргүй баримталж, тэдгээр орнуудтай «бүх талаар ойртон нягтрах» болов. Иймэрхүү бодлогын уршгаар Монгол Улс Өрнөдийн орнуудийн дунд «дагуул улс», «хаалттай орон» хэмээн нэрлэгдэх болсон юм. Түүнчлэн Өрнөдийн орнуудтай худалдаа-эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд бидэнд туршлага илт дутагдаж байсан нь нөлөөлсөн ч тодорхой. Гэвч учир шалтгааны гол нь энх тайвнаар зэрэгцэн орших зарчмын ангич, үзэл сурталжсан шинж чанар голлож байсан хүйтэн дайны үед холбоотны эрх ашгийг үндэсний язгуур эрх ашгаас дээгүүр тавьж байсанд оршино.

Социалист систем нуран унаж, хүйтэн дайн дууссаны дараах геополитикийн орчин үндсээрээ өөрчлөгдөж, далайд гарцгүй (*land-locked*), цөмийн зэвсгээр хүрээлэгдсэн (*nuclear-locked*), хоёр их гүрний дунд хашигдсан (*power-locked*), мөн монгол угсаатнаар хүрээлэгдсэн (*mongol ethno-locked*) сул бүрхүүлтэй цоо шинэ нөхцөл байдал хийгээд глобал геополитикийн орчинд Монгол Улс үндэсний язгуур эрх ашгийг дээдэлсэн, нээлттэй, энхийг эрхэмлэсэн, олон тулгуурт, бие даасан гадаад бодлого явуулах болсон нь ХХ зууны сүүлчийн улиралд Монгол Улсын гадаад бодлогод гарсан хамгийн том ололт байв.

Геополитик буюу газарзүй-орон зайн байршилд суурилж, үндсний аюулгүй байдлаас үүдэн гарсан улс төрийн бодлогод хүч чадал (*power*), нөлөө (*influence*) нэн



чухал. Энэ нь “зорилгод хүрэх хэрэгсэл, өөрөө бас зорилго бөгөөд үндэсний болон улс хоорондын улс төрийн үйл явцын гол хэрэгсэл, үндсэн зорилт” гэж стратеги судлаач Даниель С.Папп (Daniel S.Papp) тодорхойлжээ. Ханс Моргентауны (Hans Morgenthau) онолоор хүч нөлөөг ашиглаж чадах болон чадаж буй субъект, түүнд автаж буй субъекүүдийн харилцаа гэжээ. Хүч чадлын бүтэц ихээхэн чухал болой. Хүн ам бол хүч чадлын чухал бүрэлдэхүүн хэсэг мөн. Хүн амыг тооны талаас нь гадна, боловсрол, мэргэжил, насжилт, ажиллах хүчний нөөц, цэргийн насны эрчүүд зэргээс авч үзвэл хүч чадлын нэг хэсэгт тооцогдоно. Монгол Улс нижгээд сая монгол угсаатан, үндэстнээр хүрээлэгдсэн байдаг нь үндэсний аюулгүй байдалд эерэг нөлөө үзүүлж болох онцлог гэж үзүүштэй.

Газарзүйн байршил хүч чадлыг тодорхойлоход эерэг, сөрөг чухал үүрэгтэй. Евразийг дамнан орших том нутаг дэвсгэр хүч чадлыг зузаатган, бусад хүчин зүйлийн хамт үндэсний аюулгүй байдлыг хангахад чухлаар нөлөөснийг дэлхийн II дайнд ЗХУ ялсан жишээнээс харж болно. АНУ Атлантын болон Номхон далай хэмээх хоёр их халхавч бүс (*buffer zones*)-ээр хүрээлэгдсэн байдаг нь тэднийг дэлхийн I, II дайны гол өрнөлөөс тусгаарлаж чадсан бөлгөө. Израилийн геополитикийн орчин бол лалын шашинт арабын ертөнцийн бүслэлтийн төвд оршиж, цор ганцаар христийн шашныг төлөөлж байдаг нь газарзүйн эрсдэлтэй байршилд тооцогддог.

Зөвлөлт-Хятадын харилцааны дулаарал, хүйтрэл Монголын геополитикийн орчинг тодорхойлсоор ирсэн нь Монголын буфер байршилтай шууд холбогдоно. 1980-аад оны туршид олон үе шаттай явагдсан Зөвлөлт, Хятадын улс төрийн зөвлөлдөх уулзалтын үеэр Хятадын геополитикийн орчинд ЗХУ-тай харилцаагаа сайжруулахад учирч байсан «гурван харш саад»-ыг арилгах болзлыг Хятадын талаас байнга тавьж байсан нь “ямар ч тохиолдолд аливаа улсын баглан хамгаалах хүчин гагцхүү өөрийн улсын хилийн дотор байрлах ёстой” гэдэгт үндэслэж байв. «Гурван харш саад» гэдэг нь *нэгд*, Монголд байрласан Зөвлөлтийн цэрэг, *хоёрт*, Афганистанд байрласан Зөвлөлтийн цэрэг, *гуравт*, Зөвлөлтийн бүх талаар хөхиүлэн дэмждэг Социалист Вьетнам, Кампучид цэргээ байруулсан явдал бөгөөд эдгээр цэргийн бүлэглэлийг тэдгээр улсаас гаргах асуудлыг шийдвэрлэсэн тухайд л харилцааг хэвийн болгох боломжтойд оршиж байв. Тиймээс Бээжингийн удирдагчид «гурван харш саад» гэдэг нь Хятадыг гурван талаас нь бүсэлсэн байдлыг хэлж буй юм гэж Зөвлөлтийн талд тов тодорхой ойлгуулж байжээ. Өөрийн аюулгүй байдлыг хангах нь бусдын аюулгүй байдлыг ямагт хөндсөөр иржээ. Зэвсэглэлээр хөөцөлдсний гол уг сурвалж үүнд л оршиж байв.

БНХАУ оршин тогтнож байсан түүхийнхээ туршид аюулгүй байдлаа дангаараа хангаж байсан гэж үздэг. Мөн Хятад нь найрсаг хөршүүдээр хүрээлүүлж байгаагүй гэж үздэг байв. Аль ч улс, гүрнүүдийн хооронд цэрэг-аюулгүй байдлын салбарт харилцан итгэлцлийг бэхжүүлэх нь хичнээн чухал гэдэг нь эндээс тодорхой байгаа ажгуу.

Зүүн Герман, Дорнод Европ бол Варшавын гэрээний байгууллагын нутаг дэвсгэр байсан бөгөөд ЗХУ-ын асар том цэргийн бүлэглэл байрласан буфер

бүс байв. Кубын хувьсгал ЗХУ-ын дэмжлэг хүлээсэн нь АНУ-ын бөөрөнд геополитикийн чухал байршилд оршиж байсантай холбогдоно.

Хүч чадамжид хамаарах эдийн засаг-үйлдвэржүүлэлт, технологийн хөгжлийн түвшин, цэргийн хүч чадавхийн тухайд Монгол Улсын харьцуулж хэлэх зүйл тун бага юм. Байгалийн баялаг хүч чадлын чухал бүрэлдэхүүн хэсэг боловч үндэсний аюулгүй байдалд аанай л эерэг, сөрөг нөлөө үзүүлсээр иржээ. Африк тив байгалийн асар их баялагтай боловч тэр нь улс орнуудынх нь хөгжилд эерэг нөлөө үзүүлэхээсээ илүүтэй **баялгийн хараал** болтлоо сөрөг нөлөө үзүүлж ирсэн байдаг. Ирак дахь эрх чөлөө ажиллагаа, Ливи дэх арабын хувьсгалын цаана их гүрнүүдийн хар алтны төлөөх тэмцэл оршиж байсан нь нууц биш болсон билээ. ОХУ-ын эдийн засгийн сэргэлт байгалийн баялгаа хэрхэн ашиглаж, хуваарилж буйтай эрх биш холбогдоно. Хятадын эдийн засгийн үсрэнгүй хөгжлийн явц түүхий эдийн тасралтгүй хангамж нийлүүлэлтээс шалтгаалах нь тодорхой. Япон болон шинээр аж үйлдвэржсэн бар орнуудын үсрэнгүй хөгжил байгалийн баялагтай холбоогүй байдаг. Монгол Улс олон улс, үндэстэн дамнасан бизнес бүлэглэлүүдийн анхааралд өртсөн нь байгалийн үлэмж их баялаг болой. Гэвч тэрхүү баялагийн үлэмж хэсэг лиценз хэлбэрээр өрийн барьцаанд орчихсон асуудлууд буй. Уул уурхайн олборолтын үйл явцтай хамт хүрээлэн буй орчны доройтол зэрэгцэн явж байгаа нь тодорхой ажгуу. Эцэст нь хүч чадалд хамаарах нэн чухал зүйл бол ардчилсан ухаалаг засаглал, түүний чанар хийгээд засгийн эрхэнд гарсан улс төрийн намуудын төлөвшил, зөвшилцөх чадавх, удирдагчийн ур чадвар, зан суртахуун, ёсзүй, шууд нөлөө үзүүлдэг. Энэ бол Монгол Улсад хамаарах магадгүй хамгийн гол хүчин зүйл мөн болой.

### ***Дотоод аюулгүй байдлын орчин***

Монгол Улсын хөгжил дэвшил, аюулгүй байдал, гадаад орчин гэхээсээ илүүтэй гол нь дотоод орчин, төв мэдрэлийн систем, динамикаасаа шалтгаалж буй нь хэдийнээ тодорхой болчихсон зүйл юм.

**Нэгд**, Монгол Улсын гадаад, дотоод орчин сүүлийн 20 жил бус, бүр 10 жилийн өмнөхөөсөө өөрчлөгдөж, тийнхүү үндэсний аюулгүй байдлаа зөвхөн улс төр-дипломатын аргаар хангах нь өрөөсгөл хандлага бөгөөд харилцан шүтэлцээтэй ертөнцөд том, жижиг аль ч улс орнуудын өмнө тогтвортой хөгжил, амьдралын чанар, тэргүүн зэрэгт тавигдаж, ингэхлээрээ үндэсний аюулгүй байдлаа эдийн засгийн арга замаар хангах тухай асуудлыг оройд нь тавьж байгаа билээ. Хууль дээдлэх, шударга ёсыг хэлбэрэлтгүй сахих, ухаалаг засаглалыг цогцлоох, хүний эрхийн баталгааг хангах, төрийн эрх мэдлийг хязгаарлах зэрэг ардчилалын чанарын асуудал амин чухал болж байна.

Аюулгүй байдлын асуудал улам бүр хүний аюулгүй байдал дээр төвлөрлөх болов. Хүний эрхийг дээдлэх, шударга ёсыг хэрэгжүүлэх, ардчилал, амьдралын чанарыг сайжруулах нь хүний аюулгүй байдлын баталгааг хангахын чухал нөхцөл мөн.



**Хоёрт**, Монгол Улс буурай хөгжилтэй, далайд гарцгүй, дэлхийн зах зээлээс алслагдмал, цөмийн зэвсэгтэй хоёр их гүрний дунд орших боловч монгол угсаатнаар хүрээлэгдсэн онцлогтой, эдүгээ дэлхийн хамгийн хурдан хөгжиж буй бүс нутагт багтаж, эрдэс баялаг, түүхий эд, эрчим хүчний арвин нөөцтэй нь тодорхой болсныг Германы *Der Spiegel* сэтгүүлд зүйрлэснээр **«аварга баавгай, аварга лууны дундах galloper буюу чандаст хөлөг»** (pony буюу одой морьхон гэх нь хангалтгүй Д.У) бөгөөд тиймээс ч олон улсын анхаарал, их гүрнүүдийн болон үндэстэн дамнасан бизнес бүлэглэлүүдийн геополитик, гео-эдийн засгийн ашиг сонирхлыг эрхгүй татаж, энэ нь томоохон шинэ боломж, түүнчлэн томоохон шинэ эрсдлийг дагуулах болов. Далайд гарцгүй Монгол Улсын туйлын сул талыг өөрийнх нь байгалийн баялаг, үсрэнгүй хөгжиж буй Хятадын эдийн засгийн эрэлт хэрэгцээ хоёр сулруулж байгаа юм.

Монгол Улс сүүлийн 20 жилд шийдвэрлэх алхам хийсэн ч ардчилал, сайн засаглал, хүний эрхийн баталгаажилт, сонгуулийн тогтолцоо бүрэн зүгширч төлөвшөөгүй, харин ч ихээхэн эмзэг, сул, түүнчлэн ДНБ 2000 оноос хойш хэдэн арав дахин өссөн (ДНБ nominal үнэлгээгээр 2000 онд 250 гаруй сая ам. доллар байсан бол 2015 онд 12.5 тэрбум ам. доллар болов. Дэлхийн банк, ОУВС-ын мэдээ) боловч иргэдийн орлого тэр хэмжээгээр өсөөгүйгээр үл барам ядуурал улам бүр нэмэгдсэн нь улс төр-эдийн засгийн одоогийн тогтолцоо хийгээд бодлого ихээхэн гаж явж ирснийг харуулав. 2011 онд хийсэн гадаадын судалгааны дүнгээр 40 сая малтай, байгалийн үлэмж нөөцтэй хэрнээ 2,8 саяхан хүн амынх нь 70 орчим хувь нь ядуу амьдарч буй баримтыг гаргаж тавьсан билээ. Энэ бол үндэсний аюулгүй байдалд таатай сонсогдохооргүй тоон үзүүлэлт байсан бөгөөд мөн ч африк тивийн сургамжийг сануулсан хэрэг байв.

Өөр ноцтой асуудал бол ардчилал, төр засаглалын тогтолцоо өөрөө системийн гүн хямралд орсон нь үндэсний аюулгүй байдлыг ихээхэн хэврэг болгож мэдэхээр байгаа юм. Үүнд юуны өмнө сонгуулийн эрхзүйн тогтолцоо, хамтарсан болон шинэчлэлийн Засгийн газарт хамтарч тохиролцох, үгсэн хуйвалдах, засаглалын тогтолцоо алдагдаж нам төвтэй төрийн үйл ажиллагаа болсон, орлого, хууль, засаглалын тэгш бус хуваарилалт, мөнгөний томилогоо, хүний эрх бүдүүлгээр зөрчих, хариуцлага тооцох тогтолцоо, шүүх, прокурор, АТГ-ын хараат бус байдал алдагдсан, төр эрх мэдлээ хэтрүүлэх зэрэг хамаарна. Монгол Улс Үндсэн хуулийн ёсоор парламентын засаглалтай боловч хэрэг дээрээ Ерөнхийлөгчийн засаглалтай ч юм шиг болчихоод байгааг хууль, эрхзүйн хувьд тодотгож, тодорхой зааглах шаардлагатай болов. Өөрөөр хэлбэл төрийн эрх мэдлийг зааглаж, ялгааг тодорхой болгох явдал юм.

Ардчилсан Үндсэн хуулийн алтан зарчим нь гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнбугайг ч буруутайд тооцож үл болох тухай хүний эрхийг дээдлэсэн заалт бөгөөд үүнийг иргэд сайн мэддэг. Баривчлахад хүртэл эрхийг нь сануулдаг жамтай. Улс төрчид олигархуудын барьцаанд орлоо хэмээн иргэд байтугай эрхэм гишүүд өөрсдөө ихээхэн ярьж хэлэх дуртай. Олигархи гэдэг нь эдийн засгийн сонгодог утгаараа банкны эзэд, үйлдвэр-худалдааны бүлгийнхэнтэй

нэгдсэний дүнд буй болсон цөөн эздийн монопольт хамсал юм. Харин энэхүү монопольт нэгдэл улс төрчидтэй хэлхэлдсэнээр олигополийг буй болгодог. Үнэхээр Монголын төр олигополь шинжтэй болоод зогсохгүй бие биеийнхээ барьцаанд орчихоод байгаа билээ. Өнөөгийн төрд ариун явдалтан хуруу дарамд багтах агаад харин хэн нь бага, хэн нь их идсэн гэдэгт л асуудлын мөн чанар оршино хэмээн бичиж буй нь үнэнд ойрхон болой. Монголд ДНБ болон улсын төсөв хэд дахин өссөн хэрнээ иргэдийн амьжиргааны түвшин дээшлэхгүй, ядуурал ихэссээр байхад энэ их мөнгө хаашаа урсаад байгаа нь хачирхалтай. Монгол Улсын нутаг дэвсгэрийн 75 орчим хувь нь лиценз хэлбэрээр гадаадынхны эзэмшилд орсон нь тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал ямаршуухан түвшинд байсныг харуулж байсан билээ. Ганцхан уул уурхайн хөгжил Монгол Улсыг аварна хэмээн хошуурч, хошигруулж байсан үед үүнийг дагаад асар их хэмжээний мөнгөний үнэр ханхалж, улс төрчид, бизнесийн бүлэглэлийн хүсэл тачаалыг эрхгүй татсан нь бодит үнэн юм. Хамгийн ихээр идэж уух, 76 авлигач, төрөөс төрсөн тэрбумтан, олигархи төр, хэмээн цоллуулах болов. Хамтарсан Засгийн газар гэдэг нь хамтаар үгсэн хуйвалдаж идэж уухийг хэлнэ гэсэн тодорхойлт хүртэл гарсан байв. Ер нь цаашдаа УИХ-ын гишүүнд төрийн албанд сүүлийн гурав эсвэл таваас доошгүй жил ажилласан хүнийг дэвшүүлдэг баймаар санагддаг.

«Намын лидерүүд» гэж өөрсдийгөө өргөмжилсөн эрхэмүүдэд авлига, хахууль өгч сонгуулийн тойрог худалдаж авах, намын жагсаалтад дээгүүр бичигдэх, хандив, өнгө мөнгөний чансаагаар эрэмбэлэгдэж сайд даргад томилогддогийг хуулиар хориглох шаардлагатай. УИХ-ын тойрогт болон намын жагсаалтаар сонгогдсон гишүүдийн эрх, үүргийг тодорхой болгох, УИХ, Засгийн газрыг хооронд нь зааглах, УИХ-ын гишүүнийг эргэн татах эрхзүйн үндэслэлийг буй болгох зэрэг нь энэ суудал руу улайрагсад буурах нигууртай.

**Гуравт,** Эдийн засгийн өөрийгөө тэтгэх чадавхийг дээшлүүлэх, тодорхой салбарт олон улсын тавцанд өрсөлдөх чадвартай олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бүрдүүлж, салбарын тэнцвэртэй бодлого явуулах шаардлага байгаа нь тодорхой. Гэвч хөдөлмөрийн нөөцийн нэлээд хэсэг уул уурхай, түүний бичил салбар руу шилжсэнээр бусад салбарт ажиллах хүчний хомсдол буй болж, нуугдмал байсан “голланд өвчин”-ий (*dutch disease*) хам шинж (*syndrome*) илэрч эхэлсэн билээ.

Харилцан хамаарал гүнзгийрч буй ертөнцөд эдийн засгийн бие даасан байдлыг дангаараа ханган хөгжих боломжгүй ч улс орны эдийн засаг зохих түвшинд харьцангуй олон тулгууртай байх нь гарцаагүй. Нэмүү биш, харин эдийн засгийн жинхэнэ утгаараа нэмэгдсэн өртөг (*surplus value*) шингэсэн ховор элемент, нүүрс, өнгөт метал, төмөрлөг, газрын тос боловсруулах зэрэг үйлдвэржүүлтийн бодлогыг ажил болгож, Ази-Европ тивийн хооронд иж бүрэн ложистик хангагдсан «газрын гүүр» болж, үүнийг аялал жуулчлалтай хослуулсан идэвхтэй транзит орон болох ёстой. Цөмийн эрчим хүчний тухайд баримтлах бодлогыг ч нааштайгаар эргэн харах шаардлагатай.

**Дөрөвт,** Эдүгээ стратегийн ордуудаас Монголын ард түмэнд унах өгөөжийн ойрхи ирээдүй тун бүрхэг болоод зогсохгүй сүүлийн дөрвөн жилийн дотор ихээхэн хэмжээний өр (\$22 тэрбум орчим) хуримтлагдсан нь бодитой зүйл болов. Харамсалтай нь өнгөрсөн хугацаанд стратегийн шинжтэй томоохон ганц ч үйлдвэр, эрчим хүчний станц, сургууль, цэцэрлэг, төрөх эмнэлэг ашиглалтад орсонгүй. Хамгийн ноцтой нь байгалийн баялагаа ломбардад тавьснаар үүссэн зээлийн өр үүсчээ. Хүний гараар бүтээгдээгүй Монголын байгалийн их баялаг хэн нэгний бүтээж буй болгосон хувийн өмч биш бөгөөд тиймээс баялагийг хараал болгохгүйн тулд ил тод байдлын санаачлагыг ногоон эдийн засагтай нягт уялдуулж нийт ард түмэнд тэгш хүртээх нь шударга ёсонд бүрнээ нийцнэ.

Бурханаас заяасан байгалийн асар их баялгийг байгаль орчинд ээлтэй технологиор олборлож, түүний үр шимээс ард иргэд нь тэгш хүртэж, эко орчин нь тэнцвэрээ хадгалж байх шаардлагатай. Сүүлийн 25 жилд гадаадын хөрөнгө оруулалтад дулдуйдсан уул уурхай эрчимтэй хөгжсөн боловч, ард иргэдэд түүний үр өгөөж хүртээмжгүй явж ирснээр барахгүй дээрхтэй холбоотойгоор хүрээлэн буй орчны сүйрэл үргэлжилсээр байна. Үүнийг л «баялагийн хараал» (*natural resource curse*) хэмээн нэрлэдэг бөлгөө. Хэт ашгийн хойноос улайрагч гадны үндэстэн дамнасан хөрөнгө оруулагчдын хүсэл шунал, мөн ч олон улсын банк, санхүүгийн байгууллагын заавар зөвлөмж, үндэсний шинээр төрж буй баяжих нэн сонирхолтой хөрөнгөлөг этгээдүүд (мөн улс төрчид) хоёрын нийлбэрийг эдийн засгийн алуурчид буюу *economic hit men* хэмээх ажгуу. Бурхны хишгийг улс төрийн элдэв амлалттай ямар ч холбогдолгүйгээр ард иргэддээ санаачлагатай хүртээх нь аль ч УИХ, Засгийн газрын стратегийн зорилтот үндсэн ажил байх ёстой.

Шведэд «өгөөмөр төр» гэдэг нэр томъёо гарсан нь иргэний нийгмийн хамгааллын цогцолбор хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн явдалтай холбогддог. Үүгээрээ Швед улс дэлхийд дээгүүр байранд ордог агаад төр, засаг нь хүнийг «өлгийтэйгээс нь булшинд ортол тэжээдэг» гэсэн үг ч гарчээ. «Өгөөмөр төр»-д эрүүлийг хамгаалах, боловсрол олгох, нийгмийн даатгал төдийгүй тэтгэврийн асуудал багтдаг. Тэгэхдээ хүүхэд, хөгшчүүлд илүү анхаарал халамж тавьж байдгын жишээ нь үнэгүй үдийн цай хөтөлбөр хэрэгжүүлж, хичээлийн сурах бичгээр хангах, төрөл төрөгсөдөд нь эд материалын тусламж үзүүлдэг зэргийг нэрлэж болно. Настангуудад хоёроос дээш тэтгэвэр олгож буй агаад эхнийх нь өндөр насны тэтгэвэр, харин хоёр дахь нь ажилласан жилд нь олгох тэтгэвэр юм. Ингээд тэд урьд ажиллаж байсныхаа цалингийн 80 хувийг тэтгэвэрийн замаар авах боломжтой болсон бөлгөө. Монголын уул уурхайд үндэслэсэн эдийн засгийн 2011 оны 17.8 хувийн дундаж өсөлт байнгын бус байсан бөгөөд түүхийн эдийн дэлхийн зах зээлийн үнэ-ханш тогтмол эргэх мөчлөг, үе шаттай явагддаг, хамгийн гол нь энэхүү хөөсөн өсөлтөд тун болгоомжтой хандах учиртай байв.

**Тавд,** Сүүлийн 4 жилд эрчим хүч, дулааны салбарыг хувьчлах тухай салбарын яам нь бодлого болгон ярих болсон. Учир нь ингэснээр өрсөлдөөн буй болж үнэ буурах ажээ. Түлш, шатахууны салбарыг хувьчилснаар өрсөлдөөн өрнөж, үнэ

буурсангүйгээр үл барам харин ч монопольт цөөн компаниуд үгсэн хуйвалдаж, зах зээл дээр зохиомлоор үнэ хөөрөгдөж буй нь улс орны нийгэм-эдийн засаг, иргэдийн амьжиргааны түвшинд томоохон бодит аюулыг буй болгох болов. Ийм эмзэг эдийн засагтай байхад л үсрэнгүй хөгжлийн тухай хий хоосон чанга дуугарах ямар шаардлага байгаа нь ойлгомжтой. Цөөн хүн амтай, жижиг эдийн засагт чөлөөт өрсөлдөөн хэзээ ч буй болдоггүй. Үндэсний аюулгүй байдлыг баталгаажуулах, үсрэнгүй хөгжилд гол нөлөөтэй газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах асуудал тун хожуу, гэхдээ дөнгөж шийдэгдэх төлөвтэй байгаа нь улс төр-бизнесийн ашиг сонирхолтой холбоотой байж таарна.

Үндэсний аюулгүй байдлыг ноцтой хөндөж, шинээр гарч ирж буй асуудал болсон үгсэн хуйвалдаж үнэ хөөрөгдөх, УИХ-ын гишүүд өөрсөддөө мөнгө зориулж хууль батлах болсон нь инфляцийг хөөргөхөд нөлөө үзүүлсээр байсан хүчин зүйлүүдийн гол шалтгаан байв. Төрийн институтууд нүсэр байгаагийн шалтгаан нь улс төрийн намууд төрийн албыг 50:50 хувиар хуваарилж авсан явдал болой. Сүүлийн 4 жилд ажлын байр шинээр буй болсны гуравны хоёр хувь нь төрийн албанд орсноос харж болно. 81.7 сая хүн амтай ХБНГУ-д 16 яам байхад харин 3 сая хүн амтай Монгол Улсад үүнээс дутахааргүй яамд байгаа нь үүний нотолгоо юм.

**Зургаад,** Монгол Улсын МАА-н өсөх буурах, мах, махан бүтээгдэхүүн дэлхийн зах зээлийн үнэ ханш, тэгэх тусмаа хоёр хөршөөс ч үл хамаарах агаад, 2016 онд 15 сая төл хүлээн авснаар малын тоо толгой 70 саяд хүрэв. 1990 оноос хойш Монголын хүн ам ойролцоогоор 30 хувь өссөн байхад малын тоо 2.4 дахин өсчээ. 1990 оноос өмнө жилд 4.5 сая малыг хойд хөрш рүү хөлөөр нь экспортод гаргаж байв. Өнөөдөр эрүүл ахуйн шаардлага хангасан мал, мах, махан бүтээгдэхүүн их хэмжээгээр экспортод гаргаж чадахгүй байгаа юм. Ийм байхад махны үнэ ямарч үндэслэлгүйгээр 3 дахин өссөн юм. Засгийн газар дэлхийн зах зээлээс огт хамааралгүй болох махны үнийг бүрэн зохицуулж чадах байтал тэгэж чадаагүй нь эдийн засгийн далд эрх ашиг, сонирхол, дургүйд хүчгүйн шинж болой. Мах, шатахууны үний хөөрөгдлөөс олсон үлэмж их мөнгө парламентын сонгуульд зориулагддаг нь тодорхой, энэ нь бараг зуршил болов.

**Долоод,** Эзнээ олоогүй хавтгайрсан амлалтын бодлого, төрийн нүсэр институтийн зардал төсвийн алдагдлыг гааруулж, улс орныг эдийн засгийг гүн хямралд түлхдэгийг ЕХ-ны гишүүн нилээд орны хүндрэл бидэнд сануулсаар буй. Өндөр хүүтэй зээлээр тараасан, ирээдүйд улсын өр болсон 21 мянган төгрөг бол амлалтын мөнгө болохоос халамжийн мөнгө биш байсан юм. Гэхдээ энэ мөнгө олон мянган өрхийн амьжиргаанд чухал нөлөө үзүүлснийг нотлох шаардлагагүй. Сайхь мөнгөөр ихэнх иргэд архи ууж буй тухай номлож байсан нь ихээхэн эндүүрэл байсныг бөгөөд тэр нь нийгмийн маш өчүүхэн хэсэг байсныг онцлон тэмдэглэх хэрэгтэй. Амлалтын мөнгийг хүүхдийн мөнгөтэй нэг болгосон нь хамтарсан Засгийн газрын арчаагүй үйлдэл, том нүгэл болсон. Сурлагын хөшүүрэг байж, 80 түүнээс дээш үнэлгээтэй оюутнуудад тэтгэлэг болж очвол сайхь 70 мянган төгрөг

илүү үр дүнтэй байх атал хавтгайруулсан нь аанай л шинэ баян цээж өвчтэйн бэлэн жишээ. 21 мянган төгрөгийн үнэ цэнэ үний хөөрөгдөл, инфляцитайгаа хамт замхарав. 2008 оны сонгуулийн дараа Засгийн газраа дангаараа байгуулсан бол 1.5 сая, харин амлалтаа биелүүлэхээр хамтарсан Засгийн газар байгуулагдчихсан учир хоёр намын амлалтыг нэгтгээд хувьцаагаа ч, мөнгөө ч авах ёстой байв. Хэлсэн амандаа эзэн болох нь хар толгойгоо хариуцлагаас мултлах улс төрчдийн том “соёл” мөн. Гэтэл амлалтаа биелүүлж чадахгүй гэдгээ ичих ч үгүй мэдэгдсэн билээ. Хамтарсан Засгийн газар сонгуулийн бүрэн эрхийн хугацаандаа амлалтаа биелүүлсэн бол монголчууд бүгд «саятан» болох байв. Тиймээс ч хууран мэхэлж, залилан хийж засаг төрийн эрхэнд гарсан улс төрийн том нам 2012 оны сонгуульд нэр дэвшүүлэх улс төр, ёс суртахууны ямар ч эрхгүй тухай олон нийт ихээхэн шүүмжилтэй ярилцаж байсан юм.

Сүүлийн жилүүдэд УИХ-ын гишүүд өөрсдийн нэр дээр мөнгө төсөвлөж, хууль батладаг уламжлал тогтсон бөгөөд жил дараалан өсч ирсэн 1,2,3 тэрбум төгрөгөөр дүүрэг, хорооны засаг дарга нарын хийх ажлыг шүүрэн авч гүйцэтгэдэг болсон нь үнэн. Энэ нь төсвийн хөрөнгө оруулалтын бодлогын дампуурал, гишүүний хуулиар сонгуулийн тойргоо хувьчилж авах гэсэн санаархал юм. Ард иргэдэд олгож буй 21 мянган төгрөг биш, харин УИХ-ын гишүүдэд олгож буй мөнгөөр л стратегийн томоохон аж үйлдвэрийн парк, газрын тос боловсруулах үйлдвэр, эмнэлэг, сургууль, зам барьж байгуулах ёстой. Жижиг, дунд үйлдвэрийн тухайд баримталж буй бодлого ч ихээхэн алдаатай байгаа нь 1950-иад оны сүүлчээр Хятадад тунхагласан “их үсрэлт” хэмээх бодлогын хүрээнд бүх айл өрх гэрийнхээ шавар зууханд хүдэр хайлуулах ажил эрхэлснээр ган үйлдвэрлэлээр удалгүй Английг гүйцэж түрүүлэхийн үлгэртэй агаар нэг юм. Бүх хүнийг үйлдвэрлэгч болгох шаардлагагүй, тийм боломж ч байхгүй. Өрхийн аж ахуй, ЖДҮ нь хоёр өөр ойлголт бөлгөө.

**Наймд,** Иргэдийн шилжилт хөдөлгөөнийг эрхзүйн зохицуулалтгүй, хяналтгүй зоргонд нь тавьсны харгайгаар орон нутаг эзгүйрч хоосон орон зай буй болов. Энэ газар хэний нүдэнд өртөж байгааг хэлүүлэх юун. Энэхүү шилжилт хөдөлгөөний уршгаар Улаанбаатарын унаган иргэдээс хөдөөний иргэд давамгай болж, нийслэл гэр хорооллоор бүслэгдэж, хотын зам-гээвэр, боловсрол, эрүүл мэнд, эрчим хүч, усны хангамж, дулааны салбар ачааллаа даахгүй болж, хотын иргэд хэрээс хэд дахин хэтэрсэн агаарын бохирдолын гамшиг дунд амьдрах болов. Шаталт буй цагт утаа гардаг энгийн теоремыг нотлох шаардлагагүй. Гарц бол утаагүй түлш ч биш, зуух ч биш, харин Нийслэл Улаанбаатарыг задалж, гэр хороолол, оюутны хотхоныг бодлогоор үе шаттай нүүлгэн шинэ Дархан шиг дэд бүтэц бүхий шинэ Улаанбаатар хэмээх дагуул бичил хотхоныг байгуулах, Хархорумд төр засгийн зарим байгууллагуудыг шилжүүлэн байршуулах явдал юм. Гэр хороололд нарны эрчим хүчийг суурилуулах, шалнаас халах дулаалгын (олон улсын) иж бүрэн томоохон төсөл зоримог хэрэгжүүлэх шаардлагатай болов уу. Бээжин хотын утааг багасгасан гол арга хэмжээ нь түүхий нүүрс түлхийг хориглосон явдал билээ. Гэр хорооллыг



бүхэлд нь инженерийг шугамтай холбох боломжгүй ч бололцоотой хэсгүүд байгаа юм. Түүнчлэн Богд хан уулын хэд хэдэн чиглэлд Улаанбаатар-Төв аймгийг шууд холбосон нүхэн хонгил гаргах шаардлагатай. Ингэснээр Улаанбаатарын нягтрал, агаарын бохирдлыг тууштай бууруулна. Төв аймгийн нэг хэсэг газар Улаанбаатар хотын нутаг дэвсгэр болох боломж ч бүрдэнэ. Ирээдүйд нийслэлд метроны болон трамвайн шугамын үндсийг тавих шаардлагатай. Судлаачдын дүгнэлтээр нэг саяаас дээш оршин суугчидтай хотод метроны шугам тавих нь ашигтай байдаг ажээ. Улаанбаатар хотыг Төв аймагтай нүхэн хонгилоор метрогоор, алсдаа Улаанбаатар-Хархорумыг хурдны галт тэргээр холбосон тохиолдолд нийслэлийн ачааллыг үлэмж хэмжээгээр бууруулж чадна. Хүний аюулгүй байдлын нэн чухал хэмжээс болсон эрүүл, аюулгүй орчинд амьдрах, аюулгүй хүнсээр хангагдах эрх ноцтой зөрчигдсөөр байна.

**Есд,** Өнөөгийн даяаршсан ертөнцөд мэдлэг өөрөө нэн чухал мэдээлэл болж, эргээд мэдээлэл нь нэн чухал мэдлэг болж байгаа явдал бөгөөд энэхүү эргэх орчилд дүн шинжилгээний ач холбогдол тасралтгүй өсөн нэмэгдэж байна. Нэг талаас мэдээллийн орчинд даяаршсан шинэ ертөнц (*cyber space*) буй болж, мэдээлэл, харилцаа холбооны технологийн үсрэнгүй хөгжлөөс үүдэн мэдээллийн ертөнцөд томоохон өөрчлөлтүүд гарч, мэдээлэл, харилцааны цоо шинэ орчин, орон зай буй болсон явдал юм. Нөгөө талаас мэдээлэл нь өөрөө үндэсний нөөц баялаг, улс орны хөгжил дэвшилд нөлөө үзүүлэх чухал хүчин зүйл болж байгаа тухай дээр тэмдэглэсэн. Тиймээс мэдээллийн аюулгүй байдлыг найдвартай хангах нь нэн чухал болж байна. Мэдээллийн нээлттэй ил тод байдлын баталгаа ч чухал.

**Аравт,** Бидний анхаарлын гадна илэрхий орхигдож байдаг өөр нэг чухал асуудал нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг тагнуулын аргаар хангах тухай юм. АНУ, ОХУ, БНСУ, Япон, БНХАУ болон бусад орнууд үндэсний аюулгүй байдлыг хангахад тагнуулын байгууллагын ач холбогдлыг үзэл баримтлал, номлолоо нээлттэй заасан байдаг. Тагнуулын байгууллагын чиг үүрэгт эдийн засгийн аюулгүй байдлыг тагнуулын аргаар хангах, ялангуяа авилга, мөнгө угаах зэрэг гэмт хэрэгтэй тэмцэх явдал чухал болж байна. АТГ хэмээх өндөр цалин хангамжтай УИХ-ын бүтцэд ордог энэ институци улс төрөөс ангид байж, хуульшударга ёс, хүний эрхийг дээдлэх зарчмыг тууштай баримтлан үйл ажиллагаагаа шударга явуулах шаардлагатай. Өмнө нь орлогын мэдүүлэг бүртгэх, сонин хэвлэлд гарсан мэдээ, мэдээллийн мөрөөр ажлаа явуулдаг, жижиг жараахай лугаа тэмцдэг гэж олон нийт ихэнхдээ бухимддаг байсан юм. Авилга өгөх, авах үйл ажиллагаа төрийн нууцаас ч нууц байдаг нь ойлгомжтой болсон.

**Арваннэгд,** Монгол Улс мөнгө угаадаг, мөн дамжлага суваг болсон тухай бага хөндөгддөг. Хадгаламж авдаггүй, зээл олгодоггүй хэрнээ үйл ажиллагаа явуулж буй гадны хөрөнгө оруулалттай гэх зарим банк, түүнчлэн банк бус санхүүгийн байгууллага, төрөл бүрийн сангууд ихээхэн анхаарал татдаг. Бохир мөнгөний эх сурвалж нь хууль бусаар хар тамхи, мансууруулах бодис, зэвсгийн наймаа, садар самуун үзүүлбэр, хүний наймаанаас олсон орлого, авлига, албан тушаал, эрх мэдлээ



урвуулан ашигласнаас олсон орлого, үгсэн хуйвалдаж үнэ хөөргөх замаар олсон гэнэтийн ашиг, далд эдийн засгийн орлого, татвараас займчуулсан мөнгө, оюуны өмчийн эрх хулгайлснаас олсон орлого, кибер орон зайд банкны луйвар хийх, хөрөнгийн бирж дээр хууль бусаар мөнгө босгох, хуурамч мөнгийг жинхэнэ болгож солих зэрэг үйл ажиллагаанаас олсон их хэмжээний бэлэн мөнгийг санхүүгийн төлбөрийн харьцангуй биет, илүү том хэлбэрт шилжүүлэн бэлэн мөнгө, үнэт цаас, чек, алт, бараагаар сольж хууль ёсны болгох үйл ажиллагаа зэргээс үүдэлтэй. Ер нь угаасан бохир мөнгөний тодорхой хэсгийг парламент, ерөнхийлөгчийн сонгууль, улс төрийн нам, эвсэл, хөдөлгөөн, тэдний зохион байгуулсан жагсаал цуглаан, захиалгат аллагыг санхүүжүүлэх, авилга, хээл хахууль зэрэгт ашигладаг хэмээн судлаачид болон мэргэжлийн байгууллагууд үздэг. Эдүгээ уул уурхайн хөгжлийг дагаад асар их мөнгөн дүн хийгээд авлигын тухай яригдаж буй үед энэ асуудалд онцгой анхаарах ёстой. Хойд хөршид авилга, мөнгө угаасан, далд эдийн засгийн их хэмжээний орлого, татвараас зайлсхийсэн зэрэг томоохон гэмт хэргүүдийг холбооны аюулгүйн албадын оролцоотойгоор илрүүлсэн байдаг.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд гадаадад сурч, ажиллаж, амьдарч буй монгол иргэдийн аюулгүй байдал, сонгох, сонгогдох эрхийг хангах тухай ганц үг ган хийсэнгүй. Гадаад дахь монгол иргэдийн аюулгүй байдлын асуудалд анхаарлаа хандуулах нь Монгол Улсын төр, засгийн салшгүй үүрэг гэдгийг онцлон тэмдэглэх хэрэгтэй.

Монгол Улсад сайн засаглал, тогтвортой хөгжлийн баталгааг хангахад магад дахиад 10 жил шаардлагатай болов уу. Дэлхийн худалдаа-эдийн засаг, валют-санхүүгийн тогтвортой байдал Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд шууд нөлөөлөх болов. Ойрын ирээдүйн томоохон сорилт нь дэлхий түүхий эдийн зах зээл дээрх Монгол Улсын экспортын гол нэрийн бүтээгдэхүүн зэс, алт, нүүрс, ноолуур, импортын шатахууны үнийн өөрчлөлт, валютын ханшны хэлбэлзэл, төсвийн алдагдал, гадаад өр, цаг уурын өөрчлөлт, байгалийн гамшиг, уламжлалт бус шинэ өвчний цар тахал, агаарын бохирдолт, хүний эрх, хууль дээдлэх, ардчиллын чанар алдагдах, ухаалаг засаглалын төлөвшил, өмнөд, хойд хөршийн тогтвортой хөгжил зэрэг болно. Даяаршиж буй үйл явц өөрөө аливаа улс үндэстний аюулгүй байдлыг шалгах том шалгуур мөн.

### **«Гуравдагч хөрш»-ийн бодлогын парадигм**

1990-ээд оноос Монгол Улсын гадаад бодлогод гарсан шинэ парадигм бол «гуравдагч хөрш»-ийн бодлого мөн бөгөөд эдүгээ тухайлсан төрийн бодлого хийгээд онол-практикийн ахисан түвшний судалгааны шинэ чиглэл болов. Мэдээлэл, харилцаа холбооны технологийн үсрэнгүй хөгжилтэй холбоотойгоор орон зай, цаг хугацаа, хөршийн тухай уламжлалт ойлголт шинэчлэгдэж байгаатай сайхь бодлого холбогдож буй нь тодорхой. Эл бодлогын онолын үндэс нь *хүчний тэнцвэр*, (*balance of power*), *ашиг сонирхлын тэнцвэр* (*balance of interests*) бөгөөд түүнийг урт хугацаанд хадгалах тухай асуудал чухал гэдэг нь мэдээж. Улс төрийн шинжлэх ухаан, олон улсын харилцааны онол, геополитик судлалд «гуравдагч

хөрш»-ийн тухай ойлголтыг тусгайлан тодорхойлсон зүйл одоогоор хараахан гараагүй байгаа юм. Энэ утгаараа Монгол Улс бага, жижиг орны гадаад бодлого дахь «*гуравдагч хөрш*» хийгээд «*гуравдагч хөрш*»-ийн бодлого хэмээх шинэ ухагдахууныг буй болгон хэрэгжүүлж байгаа нь улс төрийн шинжлэх ухаан, олон улсын харилцааны онол, геополитик судлалын судлагдахууныг баяжуулж буй хэрэг гэж үзвээс зохилтой.

Монгол Улсын «*гуравдагч хөрш*»-ийн бодлого нь тус улс үндэсний язгуур эрх ашгийг дээдлэсэн, энхийг эрхэмлэсэн, олон тулгуурт, нээлттэй, эвсэлд үл нэгдсэн, бие даасан гадаад бодлого явуулж буйн тод илрэл юм.

«Аливаа улсын гадаад бодлого нь оршин буй газарзүйгээрээ тодорхойлогдоно» гэж Наполеон Бонапарт хэлжээ. Энэ үг газарзүйн онцлог байршилтай Монгол Улсад ихээхэн хамаатай. Улс гүрэн бүгд нэг нь нөгөөтэйгээ айл хөрш болж зэрэгцэн оршдог. Германы геополитикч, профессор Фридрих Ратцелийн (*Friedrich Ratzel 1844-1904*) «*хөршөө сонгодоггүй*» гэж хэлсэн нэгэн үг буй. Энэ бол зөвхөн хил залгасан орны тухайд өгүүлж буй хэрэг юм. Харин сайн хөршийн харилцааны тухайд бол түүнийг заавал айл зэргэлдээ гэхгүй алс холын аль ч оронтой тогтоож болно. Энэ утгаараа хөрш нь хаяа нийлсэн хэдэн ч орон байж болох бөгөөд харин хил залгаагүй хөршөө бол сонгож болох ажгуу.

АНУ-ын олон улсын харилцааны онолч, геополитикч, профессор Ханс Моргентау гадаад бодлого, дипломат ажиллагааны үндсэн дөрвөн зорилтыг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. «Дипломат бодлого хүч чадавхи, бололцоондоо тохируулан өөрийн зорилтыг тодорхойлох ёстой,
2. Дипломат бодлого нөгөө улсынхаа зорилтыг тодорхойлох ёстой,
3. Дипломат бодлого хоёр улсын зорилт хоорондоо хэр авцалдаж байгаагаа тодруулах ёстой,
4. Дипломат бодлого дээрхид тулгуурлан өөрийн зорилтыг хэрэгжүүлэх аргыг зөв сонгох ёстой»<sup>149</sup> гэжээ. Энэ нь Монгол Улсын «гуравдагч хөрш»-ийн бодлогын онол, үзэл баримтлалыг боловсруулахад судалгааны чухал аргагүй мөн.

Байнга төвийг сахих санаачилга Монгол Улсын “стратегийн түншлэл”, “иж бүрэн стратегийн түншлэл”-ийн харилцааг ямар нэг байдлаар хөнддөг. Зарим судлаачид холбоотны харилцааны ХХI зууны өөрчлөгдсөн хэлбэр нь *стратегийн түншлэл* гэж бичсэн нь ч буй. Тодорхой улс орон стратегийн түншлэлийн харилцаанд болгоомжтой ханддаг нь дээрхтэй холбоотой байж болох талтай.

«Гуравдагч хөрш»-ийн үзэл баримтлалын гол агуулга нь үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн эрх ашгийн тухай асуудал мөн болно. Монгол Улсын хувь заяа, үндэсний аюулгүй байдал болон хөгжил дэвшлийн асуудал зөвхөн хоёр хөршөөс хамаарч нөхцөлдөж байх бус, мөн дэлхийн нөлөө бүхий улс гүрнүүдийн

<sup>149</sup> Hans J. Morgenthau, *Politics Among Nations: The Struggle for Power and Peace*, 7<sup>th</sup> ed (Boston: McGraw-Hill higher education, 2006), 539-540.

геополитик, геоэдийн засаг, стратегийн сонирхол, оролцоо, нөлөө хамаарлаас давхар шалтгаалж байх улс төр, эдийн засаг, эрхзүйн орчинг бүрдүүлэхэд оршино. «Гуравдагч хөрш»-ийн бодлого гэдэг ухагдахуун нь зөвхөн газарзүйн тухай ойлголт бус, тэгэх тусмаа тухайлсан нэг улсад чиглэсэн үйл ажиллагаа бус, харин газарзүй-орон зайн онцлог байршлаас шууд үүдэн гарсан улс төр, аюулгүй байдал, эдийн засаг, геополитикийн хүрээг хамарсан олон улсын харилцааны онолын цогц ойлголт хэмээн үзвээс зохилтой. Монгол Улсын «гуравдагч хөрш»-ийн бодлого бол газарзүйн онцлог байршилтай уялдан, их гүрнүүдийн дунд хүчний зохист тэнцвэрийг барьж, үндэсний аюулгүй байдлаа улс төр-дипломатын болон эдийн засгын аргаар цогц хангах Монгол Улсын үндэсний язгуур эрх ашгаас шууд урган гарсан геополитик мөн болно.

XX зууны түүхийн огцом өөрчлөлтүүд, түүнтэй гүн гүнзгий холбоотой улс төрийн сэтгэлгээ болон орчин үеийн үеийн олон улсын харилцааны онолын хөгжилтэй уялдан *дэлхийн дэг журам* хэмээх нэр томъёо олон улсын харилцааны үзэл баримтлалын шинжтэй цогц ойлголт болон гарч ирэв. Дурьдсан ухагдахууны мөн чанар нь эмх замраагүй, хуваагдмал, олон янз, үндэсний явцуу үзэл баримтлалд суурилсан хуучин олон улсын харилцааг хүний эрх, эрх чөлөө, ардчилал, зах зээлийн эдийн засаг, олон улсын эрхзүйн хэм хэмжээнд тулгуурлан илүү зохистой глобал засаглалаар илбэн тохинуулах замаар өнөөгийн дэлхий ертөнцийг өөрчлөн байгуулах тухай асуудал юм.<sup>150</sup>

Олон туйлт дэлхийн шинэ бодлогын үзэл санаа анхлан 1997 оны 4 дүгээр сарын 23-нд Москвад гарын үсэг зурсан «Олон туйлт ертөнц, олон улсын шинэ дэг журмыг цогцлоон байгуулах тухай Орос-Хятадын Хамтарсан Тунхаглалд»<sup>151</sup> тусгалаа олсон юм. Энэхүү үзэл санаа ШХАБ, БРИКС-ийн орнуудын дээд уулзалтын баримт бичгүүдэд тусгалаа олсоор ирэв.

ОХУ-ын Гадаад хэргийн сайд С.Лавров Монгол Улсын ГХЯ-нд хийсэн уулзалтан дээр тэмдэглэхдээ: «Дэлхий ертөнц өнөөдөр түүхэн шинэ эрин үед шилжин орох үе шатандаа ирээд байна. Энэ бол бидний хийж буй ул суурьтай дүгнэлт юм. Өнөөдөр олон улсын харилцааны олон төвт бүтэц бий болж байна. Сүүлийн жилүүдэд өрнөж буй үйл явдлууд нь нэг туйлт ертөнц бий болгох оролдлого хийгээд дэлхий дахинд ганцаар давамгайлах хүсэл эрмэлзэл нь төөрөгдөлд хүргэдэг болохыг харуулж байна. Өнөөгийн нөхцөл байдалд дэлхийн аль ч улс орон, хамгийн хүчирхэг нь байлаа ч тэр, хэсэг бүлэг орнууд байгаад ч тэр орчин цагийн тулгамдсан асуудлуудыг дангаараа үр дүнтэйгээр шийдвэрлэх гэж оролдоод ч нэмэргүй нь илт болжээ. Ийм нөхцөл байдал үүссэн үед бүгдэд тулгарч буй асар том сорилт хийгээд аюул заналд оновчтой хариу барих үүднээс дэлхийн тавцан дахь үндсэн гол тоглогчдын жинхэнэ бодитой түншлэлд тулгуурлан үндэсний эрх ашиг болон хамтын дипломат үйл ажиллагааны хоорондох ухаалаг

<sup>150</sup> Д.Уламбаяр, “Дэлхийн шинэ дэг журмын талаарх зарим эргэцүүлэл,” *Стратегийн судалгаа*, (№68 4/2014): 128-137.

<sup>151</sup> Российско-Китайская совместная декларация о многополярном мире и формировании нового международного порядка. Москва, 23 апреля 1997 года (текст документа с изменениями и дополнениями по состоянию на ноябрь 2007 года)

тэнцвэрийг эрж хайх нь чухал боллоо»<sup>152</sup> гэжээ.

Бид олон улсын харилцааны олон туйлт дэлхийн шинэ дэг журамд дасан зохицож, урагш алхах шаардлагатай. ОХУ, БНХАУ-аар тэргүүлсэн олон улсын харилцааны олон туйлт төв төлөвших хандлага идэвхиж байгаа нь хүйтэн дайн дууссанаас хойш тогтсоор ирсэн олон улсын дэг журам, аюулгүй байдлын системд ноцтой нөлөө үзүүлж эхлэв хэмээн судлаачид үзсээр байгаа юм. Улс хоорондын харилцаанд шашин болон үндэстэн хоорондын мөргөлдөөн, иргэний дайн, газар нутгийн маргаан, дүрвэгсэдийн давалгаа, цөмийн болон баллистик пуужингийн хөтөлбөрөөр далайлгах, их гүрнүүдийн хоорондох ашиг сонирхлын зөрчил хурцдах төлөвтэй болж, эдийн засгийн хориг арга хэмжээ өргөжиж, **тиймээс хүйтэн дайн дууссаны дараах үе төгсгөл болж, шинэ хүйтэн дайны үе эхэллээ хэмээн тэмдэглэх нь ч буй.** Хэдийгээр их гүрнүүдийн цэргийн зардал нэмэгдэж байгаа ч энэ нь дайн гарах гол үндэслэл биш, харин аюулгүй байдлаа баталгаажуулж буй хэрэг, их гүрний байр суурь, сүр хүчээ харуулж буй хэрэг, хүчний дахин тэнцвэржүүлэлт, мөн орлогын чухал эх сурвалж байна.

Эдүгээ *нэгд*, Харилцан шалтгаалцал, даяаршлын үйл явц нийгмийн бүхий л хүрээг хамарч, гадаад, дотоод орчин маш хурдан өөрчлөгдөж, тиймээс ойрх ирээдүйн төлөв байдлыг урьдчилан төсөөлөх боломж тун бүрхэг байгаа нь өнөөгийн олон улсын харилцааны үндсэн шинж болов.

*Хоёрт*, Эдүгээ олон улсын хамтын ажиллагааны хамгийн чухал зүйл нь олон улсын харилцаа, геополитикийн орчинд урьдчилан таамаглаж болохуйц нөхцөл байдлыг хадгалах явдал тулгамдсан асуудал болсоор байна.

*Гуравт*, хүчний тэнцвэрийг барихаас гадна ашиг сонирхолын тэнцвэрийг барих гэдэг маш чухал болов.

*Дөрөвт*, Төв рүү тэмүүлэх, төвөөс зугтаах хүчний аль аль нь үйлчилж буй даяаршлын эрин үед олон улсын харилцааны шинэ дэг журам төлөвших үйл явцын төгсгөлийг төсөөлөх боломж тун бүрхэг байгаа зэрэг санал, дүгнэлтүүд юм. Brexit, АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн дүн, ШХАБ, Евразийн Эдийн Засгийн Холбоо, Торгоны их замын мега төслийн үйл явц үүний тод илрэл юм.

Улс орнуудын өмнө *нэгд*, дэлхийн дулаарал, цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох, *хоёрт*, даяаршиж буй дижитал ертөнцөд дасан зохицохоос гадна, *гуравт*, олон улсын харилцааны олон туйлт дэлхийн шинэ дэг журам төлөвших үйл явцад нэгэн адил хэрхэн дасан зохицох тухай асуудал шинээр дэвшигдэн тавигдаж байна. Эдгээр үйл явцтай санал нэгдэх нь эрх ашгийн тэнцвэр юм.<sup>153</sup> Эрх ашгийн тэнцвэр нь хамтаар хожиход оршино.

Бид *нэгд*, олон туйлт дэлхийн шинэ дэг журам төлөвших үйл явцад гурвалсан хөршийн бодлого, «гуравдагч хөрш»-ийн бодлогын хооронд хүчний тэнцвэр, эрх

<sup>152</sup> Выступление и ответы на вопросы Министра иностранных дел России С.В.Лаврова на встрече в МИД Монголии, Улан-Батор, 14 апреля 2016 года

<sup>153</sup> Газрын тосны олборлалтыг хязгаарлах талаарх ОПЕК, ОХУ-ын тохиролцоо бол эрх ашгийн тэнцвэр юм.

ашгийн тэнцвэрийг зөв барих явдал чухал боллоо. Монгол Улсын «гуравдагч хөрш»-ийн бодлогоо хэрэгжүүлэх гадаад орчин 1990-ээд оноос үндсээрээ өөрчлөгдсөн гэдгийг онцлон тэмдэглэх хэрэгтэй. *Хоёрт*, Өрнөдийн хориг арга хэмжээтэй холбоотойгоор ОХУ-ын Алс Дорнодын бодлого, ялангуяа БНХАУ-ыг чиглэсэн бодлого идэвхижсэн нь Монгол Улсын геополитикийн ач холбогдлыг мэдэгдэхүйц өсгөв. Бид үүнийг дорвитой ашиглаж чадаагүй л байна. *Гуравт*, Орос-Хятадын харилцаа иж бүрэн стратегийн түншлэлийн баттай түвшинд хүрсэн нь Монгол Улсын гадаад хамгийн ойр орчин сайн байна гэсэн үг.<sup>154</sup> *Эцэст нь*, Монгол Улс олон туйлт дэлхийн шинэ дэг журам төлөвших үйл явцын яг төвд нь оршиж байна. ОХУ, БНХАУ-ын оройлолтой олон туйлт дэлхийн шинэ дэг журам төлөвших үйл явцад ШХАБ, БРИКС<sup>155</sup>, ЕАЭЗХ, АДБХОБ, Торгоны их замын дагуух “Нэг бүслүүр, нэг зам,” мега төсөл чухал үүрэг гүйцэтгэж байна гэж үзэж байгаа юм.

Монгол Улсын гуравдагч хөршийн бодлого нь 2 үе шатыг дамжин явагдаж байна гэж үзэж болохоор байна. *Нэгдүгээр үе шат нь*: Unipolarity (Pax Americana, American Primacy) буюу нэг туйлт дэлхийн шинэ дэг журам зонхилж байсан үе. Энэ үеийн гол агуулга нь өрнө, дорнын хөгжингүй ардчилсан гүрнүүдийн улс төр-дипломатын дэмжлэг, эдийн засгийн бодит ашиг сонирхолыг Монгол Улсад буй болгох чиглэлтэй байв. Дурьдсан үед ОХУ-ын нийгэм-эдийн засаг нэн хүндрэлтэй, БНХАУ-ын эдийн засаг хурдацтай хөгжлийнхөө үе шатанд явж байв. Үндсэндээ үсрэнгүй хөгжлийн оршил үедээ урагшилж байжээ. Монгол Улс 1993 онд ОХУ-тай, 1994 онд БНХАУ-тай «Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны Гэрээ»-г тус тус байгуулсан нь нэн чухал ач холбогдолтой байв. 1994 оны «Гадаад бодлогын үзэл баримтлал»-д «гуравдагч хөрш»-ийн бодлогыг “дэлхийн бодлогод жин нөлөөтэй гүрнүүдийн эдийн засгийн бодит ашиг сонирхолыг Монгол Улсад буй болгох” гэж томъёолсон юм. Харин үзэл баримтлалд Дани, Нидерланд, Финлянд, Австри, Швед, Швейцари, Энэтхэг, Өмнөд Солонгос, Тайланд, Сингапур, Турк улсыг нэрлэсэн ч Монгол Улсын чухаг түнш Их Британи, Франц, Итали, Бельги, Канад болон ЕХ-г огт дурдалгүй орхигдуулсныг тэмдэглэх хэрэгтэй. *Хоёрдугаар үе шат* бол A New Multi-Polar World буюу олон туйлт дэлхийн шинэ дэг журам төлөвших үе шатан дахь Монгол Улсын «гуравдагч хөрш»-ийн бодлого хэмээн тодорхойлж байгаа юм.<sup>156</sup> Энэ үе бол ОХУ, БНХАУ-аар тэргүүлсэн, мэдээж АНУ, Энэтхэг оролцсон олон улсын харилцааны систем тогтож байна.

<sup>154</sup> В.Путин 2012 оны 3 дугаар сард ОХУ-ын Ерөнхийлөгчөөр гуравдахь удаагаа сонгогдсоны дараа гадаад анхны айлчлалаа мөн оны 6 дугаар сард БНХАУ-аас эхэлж, хоёр орны бүх талыг хамарсан стратегийн түншлэл (Россия и Китай выходят на новый уровень отношений-уровень всеобъемлющего стратегического партнерства)-ийг шинэ түвшинд хүргэх тухай Бээжингийн Тунхаглалд гарын үсэг зурсан юм.

<sup>155</sup> Судлаачид Бразил, ӨАБНУ-ын эдийн засгийн хүндрэлтэй байдлаас БРИКС-ийн үүрэг бүдгэрч байна гэж үзэх болсон.

<sup>156</sup> 2016 оны 10 дугаар сарын 16-нд Энэтхэгийн Гоа мужид зохиогдсон БРИКС-ийн дээд уулзалтаас гаргасан Гоагийн Тунхаглалд: “...зөвхөн олон улсын эрхзүйг дээдэлж, НҮБ-ын гол үүрэгт суурилсан олон туйлт олон улсын дэг журмыг цогцлоон байгуулах” тухай заасан байна.

## ДҮГНЭЛТ

ОХУ, Монгол Улсын холбоотны харилцаа үгүй болж, шинээр стратегийн түншлэлийн харилцааг тогтоосон хэдий ч Монголын «буфер улс»-ын гүйцэтгэдэг геополитикийн үүрэг хэвээр, нөгөө талд XXI зуунд Өмнөд хөршийн эдийн засаг үсрэнгүй хөгжих болсон нь сайхь улс геополитик, гео-эдийн засгийн нөлөөний хүрээгээ өргөжүүлэх өргөн боломжтой болж байгааг өрнөдийн судлаачид «Хятадын аюул» хэмээн нэрлэдэг нь огт үндэслэлгүй зүйл биш юм. Бид Монгол Улсын гадаад бодлого, түүний шийдвэр гаргах ажиллагааны шинжлэх ухаан-онол аргагүйн үндсийг улам бүр боловсронгуй болгох шаардлагатай. Хөгжиж буй улсын үндэсний дэвшил, аюулгүй байдлын баталгаажилтын чухал эх сурвалж нь идэвхтэй бөгөөд оновчтой гадаад бодлого, дипломат ажиллагаа даруй мөн. Гадаад бодлого бол өөрөө батлан хамгаалах том арга хэрэгсэл хэмээн дээр тэмдэглэсэн.

Монгол Улсын «гуравдагч хөрш»-ийн үзэл баримтлалын гол агуулга нь *Монгол Улсын хувь заяа, үндэсний аюулгүй байдал болон хөгжил дэвшлийн асуудал зөвхөн хоёр хөршөөс хамаарч нөхцөлдөж байх бус, мөн дэлхийн нөлөө бүхий улс гүрнүүдийн геополитик, геоэдийн засаг, стратегийн сонирхол, оролцоо, нөлөө хамаарлаас давхар шалтгаалж байх улс төр, эдийн засаг, эрхзүйн орчинг бүрдүүлэхэд оришино. Монгол Улсын «гуравдагч хөрш»-ийн бодлого бол газарзүйн онцлог байршилтай уялдан, их гүрнүүдийн дунд хүчний зохист тэнцвэрийг барьж, үндэсний аюулгүй байдлаа улс төр-дипломат болон эдийн засгийн аргаар цогц хангах Монгол Улсын үндэсний язгуур эрх ашгаас шууд урган гарсан геополитик мөн. Нөгөө талд хоёр хөршөөс Монголын тухайд явуулж буй геоэдийн засгийн бодлого нь «гуравдагч хөрш»-ийн эрх ашгийг ямар нэг хэмжээгээр давхар хөндөж байх явдал болно.*

«Гуравдагч хөрш»-ийн бодлого бол зөөлөн хүчний бодлого мөн. Жозеф С.Най судлаачийн тэмдэглэсэнээр: “зөөлөн хүч” гэдэг нь албадлага, заналхийлийн бодлогоо тулгахаас зайлсхийн, түүх, соёл, улс төрийн үнэт зүйлс, ёс зүйтэй гадаад бодлогын манлайллаар бусдын сэтгэлийг татах, улмаар хүссэн үр дүнд хүрэх улс төрийн бодлогын арга хэрэгсэл юм.<sup>157</sup>

«Гуравдагч хөрш»-ийн бодлого нь үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн эрх ашгийн тухай асуудал гэж дээр тэмдэглэсэн. Хөгжлийн асуудал тэргүүн зэрэгт тавигдаж буй өнөө үед бага жижиг улсын аюулгүй байдал, тусгаар тогтнол, хөгжил дэвшил гадаад эдийн засгийн харилцаа, түүнээс гарах үр өгөөжтэй амин чухал холбоотой.

«Гуравдагч хөрш»-ийн бодлогоо сүүлийн жилүүдэд олон улсын хэмжээнд дэмжүүлэх тухайд дорвитой алхам хийсэнгүй. Энэ чиглэлд АСЕМ-11 Улаанбаатарын дээд түвшний уулзалт хамгийн таатай боломж байсан боловч дурьдсан асуудлыг хэлэлцүүлээгүй орхигдуулсан нь харамсалтай. Дурьдсан хоёр

<sup>157</sup> Joseph S. Nye, *Bound to Lead: The Changing Nature of American Power*; Basic Books (New York: Basic Books, 1990), Chapter II.



асуудалд ЕХ, АСЕАН-ны улс төрийн дэмжлэг чухал байсан нь мэдээж. АСЕМ-11 илүү баяр ёслолын шинжтэй болж өндөрлөснийг тэмдэглэх хэрэгтэй.

Монгол Улсын «гуравдагч хөрш»-үүдийг бүсчлэн үзвэл Хойд Америкт: АНУ, Канад, Зүүн хойд Азид: Япон, БНСУ, Европ тивд ЕХ, түүний нөлөө бүхий гишүүн орнууд, лалын ертөнцөөс: түүх, хэл, соёлийн эртний гүн хэлхээ холбоотой, олон намын тогтолцоотой ардчилсан, Их 20 бүлгийн гишүүн, ЕХ-ны гишүүнчлэлд нэр дэвшээд удаж буй Турк, физик-газарзүйн талаасаа хамгийн ойр [жар орчим км-ын цаана] орших Казахстан, «оюун санааны хөрш» хэмээн нэрлэдэг, түүх, соёл, шашин шүтлэгийн эртний уламжлалт гүн харилцаатай Энэтхэг улсыг хамруулж байна.

Одоогийн байдлыг ажиглавал Монгол Улсын «гуравдагч хөрш»-ийн бодлого нь урт удаан хугацаанд үргэлжлэх төлөвтэй бөгөөд, тиймээс залгамж шинжтэй байх ёстой.

АНУ-ын элчин сайд Жонатан Эдлтон *«Нэгэн чухал хүчин зүйл: АНУ-Монгол Улсын дипломат харилцаа, 1987-2012»* сонирхолтой бүтээлдээ: **«Дотоод асуудал дээр ам хэлээр тохиролцож, заримдаа ширүүн мэтгэлцдэг ч гадаад бодлогын асуудлаар дэлхий нийтэд нэгдмэл байр сууриа харуулахыг хүсч буй Монголын улс төрчид үндэсний хэмжээний зөвшилцөлтэй байх хүнд ачааг зайлиггүй үүрч байна. Монгол Улсын гадаад бодлого дахь одоогийн чиг хандлагаас харахад хөрш хоёр оронтойгоо бат бэх харилцааг үргэлжлүүлэхийн зэрэгцээ шинэ томъёолол болох «гуравдагч хөрш»-өө олон янзаар хайж байна. Монгол Улс үүнийг илүү амжилттай хийх тусам цаашид улам амаргүй болж болох юм. Олон улсын тавцанд Монгол Улс ерөнхийдөө нэр хүнд ихтэй байгаа нь энэ үйл явцыг илүү хялбар болгоход тус дөхөм болно»**<sup>158</sup> гэсэн анхаарал татсан дүгнэлт хийсэн байна. «Гуравдагч хөрш»-бодлогын хүрээнд Өрнө, Дорнын хөгжингүй, ардчилсан орнуудын Монгол дахь эдийн засгийн бодит сонирхолыг буй болгох чиг шугам тодорхой сорилтуудтай тулгарч байгааг тэмдэглэх ёстой. Гэхдээ зарим улс төрчдийн хэлж буйчлан дээрх баримт нь Монгол Улсын «гуравдагч хөрш»-бодлогын нуралт биш бөгөөд «гуравдагч хөрш»-бодлогын улс төрийн чиглэл нь тодорхойлогч шинжтэй гэдгийг онцлон тэмдэглэе.

<sup>158</sup> Addleton Jonathan S, A Most Helpful Factor: US-Mongolia Diplomatic Relations, 1987-2012. Weatherford Foundation, Ulaanbaatar.: 2012, p. 161

### НОМ ЗҮЙ:

1. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ: 2010
2. Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал. УБ.: 2011
3. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын гадаад, дотоод орчны судалгаа, дүн шинжилгээ. УБ.:2014
4. Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлого: гуравласан хамтын ажиллагааг хөгжүүлэх боломж. УБ: 2017
5. Morgenthau Hans J. Politics Among Nations: The Struggle for Power and Peace. N.Y.: *Seventh edition*. 2006, pp. 539-540
6. Anita Sengupta, Heartlands of Eurasia: The Geopolitics of Political Space, Lexington Book.: 2009, 220 ps
7. Joseph S. Nye. Bound to Lead: The Changing Nature of American Power, Basic Books: 1990
8. Addleton Jonathan S. A Most Helpful Factor: US-Mongolia Diplomatic Relations, 1987-2012. Weatherford Foundation, Ulaanbaatar.: 2012
9. Российско-Китайская совместная декларация о многополярном мире и формировании нового международного порядка. Москва, 23 апреля 1997 года (текст документа с изменениями и дополнениями по состоянию на ноябрь 2007 года)
10. Выступление и ответы на вопросы Министра иностранных дел России С.В.Лаврова на встрече в МИД Монголии, Улан-Батор, 14 апреля 2016 года

